



МОНГОЛ УЛСЫН ГЭГЭЭРЛИЙН САЙДЫН ТУШААЛ

1999 оны 05-р сарын 25 өдөр

Дугаар 113

Улаанбаатар хот

Магистрантурт
сургах тухай


ТУШААХ НЬ:

1. Авирмэдийн Түвшинжаргал, Дондовын Долгорсүрэн, Рагчаагийн Баяржавхлан нарыг ХБНГУ-ын Маннхайм хотын Гетёгийн Институтын хэлний 3 сарын бэлтгэлд DAAD (Германы эрдэм солилцооны алба)-ын зардлаар 1999 оны 6 дугаар сарын 10-аас суралцуулсугай.

2. Хэлний бэлтгэлээ амжилттай дүүргэж, ХБНГУ-ын их дээд сургуулиудын магистрантурт элсэн орсон хүмүүстэй Гэгээрлийн сайд, Сангийн сайдын 1998 оны 67/131 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орнуудын магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, 1999 оны 10 дугаар сарын 1-нээс холбогдох төлбөр тооцоо хийхийг Сургалтын төрийн сангийн захирал /Б.Ганбат/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /С.Алтангэрэл/-д тус тус даалгасугай.



САЙД


А.БАТТӨР

1 Күрэт суралцах нөхцөл тушаал гаргах